



ХОТ, СУУРИНЫ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагын талаар

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан.

Түүнчлэн Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Хот, сууринг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламж байгуулах ажлыг холбогдох хуулиар зохицуулна” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 4.38-д “Хот, суурин газрын ногоон байгууламжид чиглэсэн үйл ажиллагаа нь одоо байгаа ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн сэргээлт, нөхөн тарилт хийхэд чиглэгдэж, харин шинээр байгуулагдаж байгаа ногоон байгууламж нь хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангаж чадахгүй байна. Улсын хэмжээнд хот, суурин газрын ногоон байгууламжийн талаарх эрх зүйн нэгдсэн зохицуулалт байхгүй, зөвхөн орон нутгийн хэмжээнд холбогдох салбарын дүрэм, журмаар зохицуулж байгааг өөрчлөн хуульчлах.” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр”-ийн 1.7-д “Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл шинээр боловсруулж батлуулах” гэж, түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 6.3.1-д “Хот, суурины ногоон байгууламжийн тухай эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх” гэж тус тус заасан.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны улмаас монгол орны экосистемд мэдэгдэхүйц өөрчлөлт орж, энэ нь цөлжилт, ган, зудын давтагдал ихсэх, усны нөөц, биологийн олон янз байдал хомсдох зэргээр илэрч, Монгол Улсын нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээ ихэнх хөгжиж байгаа орон болон дэлхийн дунджаас өндөр түвшинд хүрсэн бөгөөд Улаанбаатар хотын нэг хүнд 3.7 м² ногоон байгууламж оногдож байгаа нь олон улсын хотуудын жишгээс 2-3 дахин бага байна. Гэтэл нэг га талбайн мод, сөөг нь 18 сая шоо метр агаарыг цэвэршүүлж, утаа униарын 30-35

хувийг өөртөө шингээдэг. Өвлийн улиралд модлог ургамал навч шилмүүсгүй болсон үедээ ч агаарын бохирдлыг 40 хүртэл хувь багасгаж, дуу чимээний 26 хувийг шингээдэг.

Ийнхүү ногоон байгууламж нь хотын хүн амд эрүүл ахуй, гоо зүйн олон талын ач холбогдолтой учраас ногоон ургамлаар хотыг цэцэрлэгжүүлэх ажлыг хот байгуулалтын ажлын бүрэлдэхүүн хэсэг болгон олон оронд өндөр түвшинд хийж ирснийг судлаачид тогтоосон байдаг.

Хүн ам өсөхийн хэрээр хотжилт эрчимтэй явагдаж Монгол Улсын нийт хүн амын 60 гаруй хувь нь Улаанбаатар хот, аймгийн төв болон тосгон, суурин газарт оршин сууж байна. Манай орны хувьд хот, суурин газрын ногоон байгууламжид чиглэсэн үйл ажиллагаа нь одоо байгаа ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн сэргээлт, нөхөн тарилт хийхэд чиглэгдэж, харин шинээр байгуулагдаж байгаа ногоон байгууламж нь хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Хот, суурины ногоон байгууламжийн талаарх зохицуулалт нь Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Газрын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Барилгын тухай, Хот байгуулалтын тухай, Байгалийн ургамлын тухай, Тариалангийн тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай зэрэг хуулиудын холбогдох заалтуудаар, түүнчлэн тухайн засаг захиргааны нэгжид мөрдөх захиргааны хэм хэмжээний акт, салбарын норм, дүрмээр зохицуулагдаж байгаа хэдий ч ногоон байгууламжийг хэрхэн ашиглах, арчлан хамгаалах, энэхүү үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, энэ чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд, судалгаа шинжилгээний байгууллагуудад тавигдах шаардлага, тэдгээрийг дэмжих, хот, суурины ногоон байгууламжтай холбоотой харилцаанд оролцогч этгээдүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог тусгасан нэгдсэн зохицуулалт байхгүйгээс бүтээн байгуулалтын ажлын явцад ногоон байгууламж устах, тоо хэмжээ буурах, хот, суурин газрын орчны бохирдол байнга өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Түүнчлэн хот, суурин газрын иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчин нөхцөлийг хангах, хөдөлмөрийн бүтээмж дээшлүүлэх, барилгажсан нутаг дэвсгэрийн архитектур, орон зайн тааламжтай орчин бүрдүүлэх, дуу, чимээ, агаар, ус, хөрсний бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлэх, түүнчлэн суурин газрын оршин суугчдын эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах үндсэн эрхийг хангах зорилгоор дээрх асуудлуудаар нэгдсэн зохицуулалт бүхий хуулийн төсөл боловсруулах шаардлага зүй ёсоор бий болж байна.

Дээрх хууль зүйн болон практик шаардлагын дагуу Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлох талаар

1.Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төсөлд Монгол Улсын хот, суурины ногоон байгууламжийг ногоон хөгжлийн бодлого, хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөх, байгуулах, арчлан хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх болон эдгээрт хяналт тавих, санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааны талаар нарийвчлан тусгана.

2.Мөн нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлттэй уялдуулан хот, суурины ногоон байгууламжийн тоо, хэмжээг нэмэгдүүлэх, тухай хот суурины ногоон байгууламж дахь ургамлын амьдрах чадварыг сайжруулан, төрөл, зүйлийн бүрдлийг байгуулах асуудлыг тодорхой тусгана.

3.Ногоон байгууламжийг байгуулах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах үүрэг бүхий цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тусгана.

4.Ногоон байгууламжийг зохистой ашиглах, барилга, байгууламж, зам, инженерийн шугам сүлжээг төлөвлөх, зураг төсөл зохиох, бүтээн байгуулалтын болон засвар үйлчилгээний ажил гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зөвшөөрөл авах, ногоон байгууламжид хохирол учруулахаас сэргийлэх, хохирол учруулсан нөхцөлд ногоон байгууламжийг нөхөн сэргээж, ногоон байгууламжийн экологи, эдийн засгийн үнэлгээний дагуу нөхөн төлбөр төлөх, орон нутгийн удирдлагын болон мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөн үйл ажиллагаагаа явуулах зэрэг оролцогчдын нийтлэг эрх, үүргийг тусгана.

5.Иргэн, хуулийн этгээдийг ногоон байгууламж байгуулах, хамгаалах үйл ажиллагаанд идэвх, санаачлагатай оролцуулах нөхцөлийг хангах үүднээс холбогдох үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийг хөхиүлэн дэмжих зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Монгол Улсын иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах нөхцөл бүрдэнэ.

Хот, суурины газар ашиглалтын зөв хуваарилалт бий болж, хот, суурины өнгө үзэмжийг сайжруулах, орон зайн зөв шийдэл бүхий ногоон байгууламжууд нь хот төлөвлөлтийн бүрэлдэхүүн хэсэг болох эрх зүйн орчин бүрдэх бөгөөд ногоон байгууламжийн менежментийг шинээр бий болгох, төрөөс ногоон байгууламжийн талаар баримтлах бодлого, хөгжлийн баримт бичгийг орон нутагт хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бий болно.

Түүнчлэн хот, суурины ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын тогтвортой тогтолцоо бүрдэж, ногоон байгууламжийн талаарх төр, иргэн, хуулийн этгээдийн хоорондын ажлын уялдаа холбоо сайжирч хот суурины агаар, ус, хөрсний бохирдлыг буурах, дуу чимээ багасахад тодорхой нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуультай бүрэн нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---o0o---